

ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГУУД*

1. Эдийн засгийн зохион байгуулалтын холбоо (товчоор: Кэйданрэн)

1946 онд байгуулагдсан тус холбоо нь Японы эдийн засгийн хамгийн хүч нөлөөтэй том байгууллага юм. Холбооны үйл ажиллагааг ерөнхийлөгчөөс гадна 13 дэд ерөнхийлөгч эрхлэн явуулдаг. Холбооны ерөнхийлөгчийг «санхүүгийн ерөнхий сайд» гэж ч нэрлэдэг.

Эдийн засгийн янз бүрийн байгууллага, бүлгүүдийг холбодог тус холбоо нь улс төр, эдийн засгийн амин чухал асуудлаар засгийн газар, парламентэд саналаа оруулж, төрийн бодлогыг боловсруулахад хамтран ажилладаг. Мөн гадаад харилцаа, хүн амын амьжиргааны байдал, боловсрол, байгаль орчны асуудал зэрэг өргөн хүрээтэй салбараар судалгаа шинжилгээ явуулдагаас гадна гадаад орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өрөгжүүлэн хөгжүүлж байна.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Ерөнхийлөгч Сайто Эйширо нь 1911 онд Ниигата мужийн Нийгата хотод төрсөн бөгөөд Шиннихонсэйтэцү нэгдлийн хүндэт ерөнхийлөгч юм. 1935 онд Токиогийн их сургуулийн эдийн засгийн факультетийг төгсөөд Мицубиши пүүсийн уулын олборлох үйлдвэрт орсон. 1970 онд Явата, Фүжи пүүс нэгдсэнээр Шиннихонсэйтэцү пүүс буй болж ерөнхий захирлаар томилогдсон. 1977 онд пүүсийн захирлаар, 1981 онд холбооны ерөнхийлөгчийн алба хашиж байгаад 1986 оны 5-р сард 2 дахь удаагаа ерөнхийлөгчөөр сонгогдсон. Сайто Эйширо «Харанхуйг үзэлгүйгээр гэрэл гэгээ рүү тэмүүлцгээ» гэсэн лоозон дэвшүүлсэн. 1987 онд хүндэт ерөнхийлөгч болсон.

ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

1. Хирайва Гайши нь эдийн засгийн зохион байгуулалтын холбооны дэд ерөнхийлөгч бөгөөд 1914 онд Айчи мужийн Токонамэ хотод төрсөн. Токиогийн цахилгаан эрчим хүчний холбооны дарга бөгөөд 1939 онд Токиогийн их сургуулийн хууль зүйн факультетийг төгссөн. 1971 онд хувь нийлүүлэгч пүүсүүдийн хэрэг эрхлэх дарга (нарийн бичгийн дарга), 1974 онд пүүсийн орлогч дарга, 1976 онд пүүсийн дарга, 1984 оноос цахилгаан эрчим хүчний холбооны дарга хийж байна. 1978 оны 5-р сард 6 дахь удаагаа холбооны дэд ерөнхийлөгчөөр сонгогдсон.

2. Тоёода Эйжи 1913 онд Айчи мужид төрсөн. Машины Тоёота пүүсийн нэгдлийн ерөнхийлөгч. 1939 онд Токиогийн их сургуулийн техникийн ухааны салбарын инженер механикийн факультетийг төгсөөд Тоёода машин угсралтын үйлдвэрийн цехэд орж ажилласан. Америкт сургуульд явж Форд пүүсийн техникийн уран чадвараас суралцаж 1955 онд сурсан үр дүнгээ нэгтгэж «машины углаа цагираг» зохион бүтээсэн нь Тоёотаг хөгжүүлэх үндэс болсон. Үүний дараагаар 1966 онд алдарт «Кароола» машиныг зохион бүтээсэн.

3. Канамори Масао 1914 онд Ямакучи мужид төрсөн. Мицубиши пүүсийн хүнд аж үйлдвэрийн зөвлөх, 1935 онд Кюүшюү их сургуулийн технологийн факультетийн металургийн ангийг төгсөөд Мицубиши пүү-

* Imidas 1990, Tokuo, p, 134 — 136

сийн хүнд үйлдвэрийн харьяа Нагасаки хотын хөлөг онгоцны үйлдвэрт орсон.

4. Нагаяма Токи -0 1912 онд Канагава мужид төрсөн. Шёовашиэру (Шоова) нефть хийн нэгдлийн дарга,

5. Исода Ичироо 1913 онд Кумамото мужид төрсөн. Сумимото пүүсийн банкны хорооны дарга,

6. Мацузава Такужи 1913 онд Токио хотод төрсөн. Японы ажил эрхлэгчдийн холбооны орлогч дарга, Фүжи банкны зөвлөх.

7. Яхиро Тошикуни — Мицуи буссан үйлдвэрийн дарга. 1915 онд Токио хотод төрсөн. 1940 онд Токиогийн худалдааны дээд сургууль (одоогийн Хитоцу башигийн их сургууль)-ийг төгссөн.

8. Хижиката Такэши - Сумимото пүүсийн химийн аж үйлдвэрийн захирал. 1915 онд Гифү мужийн Эна хотод төрсөн.

9. Саба Шёоичи — Тошиба пүүсийн зөвлөх. 1919 онд Токио хотод төрсөн.


10. Морита Акио - Сони нэгдлийн дарга. 1921 онд Айчи мужийн Токонамэ хотод төрсөн.

11. Каваи Рёоичи — Комацу үйлдвэрийн дарга. 1917 онд Токио хотод төрсөн.

12. Ханамура Нихачироо -Эдийн засгийн мэдээллийн төвийн дарга. 1908 онд Фукуока мужийн Иизука хотод төрсөн.

ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХОЛБООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ

(1,131 ГИШҮҮНТЭЙ)



II. Эдийн засгийн хөгжлийн хороо


Энэ хороо анх 1946 оны 4-р сард байгуулагдахдаа «Япон орныг

шинэчлэн байгуулах нь бидний зорилго бөгөөд туйлын их ардчилалтай, энхийг эрхэмлэгч, соёлт гүрэн болгоход оршино» гэж тунхагласан. Энэ нь «Улс орныхоо эдийн засгийг шинэчлэн өөрчлөхөд улс төрийн бодлогоор нээлттэй үйл ажиллагаа явуулах талаар бүх хүч чадлаа зориулъя» гэсэн зорилгоор нэгдсэн аж ахуйг хөтлөгч менежерүүдийн байгууллага юм. Эдийн засгийн 4 байгууллага дотроос энэ хорооны онцлог нь хувь хүнийг эрх зүйн дагуу нэгтгэн элсүүлж, үйлдвэр аж ахуйн газрын байр сууринаас биш, улс ардын аж ахуйн талаас нь улс орны дотоод гадаад нийгэм эдийн засгийн тэргүүний дэвшилт санаачлага, эрэлт шаардлагатай асуудлаар мэдээлэл хийдэгт оршино.

1. Ишихара Такаши нь 1912 онд Токио хотод төрсөн. Японы машины үйлдвэрийн дарга, мөн Ниссан машины нэгдлийн ерөнхийлөгч 1937 онд Тоохокугийн их сургуулийн хууль цаазны ухааны салбарыг төгсөөд Ниссан пүүсэд орсон. «Худалдаа арилжааны чөтгөр» гэж хочлуулж нэр цуутай «Санин» машиныг их амжилтанд хүргэсэн. 1960 онд Америкт Ниссан пүүсийг байгуулж өөрөө пүүсийн дарга нь болсон. 1980 онд машины аж үйлдвэрийн дарга, америкт машиныг экспортлох бодлого боловсруулахад голлон оролцсон. Улмаар Итали, Испани, Англи руу үйлдвэрүүдээ нэвтрүүлэн машины аж үйлдвэрийг олон улсын шинж чанартай болгоход их хувь нэмэр оруулсан. 1977 онд пүүсийн дарга, 1985 оноос хорооны даргын албан тушаалыг хашиж байна.

2. Кавай Сабуроо -Эдийн засгийн хөгжлийн хорооны нарийн бич-

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХОРООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Нийт 1547 гишүүнтэй

гийн даргын орлогч, ерөнхий захирлыг хавсардаг. Олон улсын хөгжлийн төвийн дарга, 1922 онд Токио хотод төрсөн.

3. Табучи Сэцуя — Хорооны нарийн бичгийн даргын орлогч. 1923 онд Окаяма мужид төрсөн. Номура Шёокэн пүүсийн дарга.

4. Насу Шёо — Хорооны нарийн бичгийн даргын орлогч. 1924 онд Миягэ мужид төрсөн. Гокио Дэврёку пүүсийн дарга,

5. Сэкимото Тадархиро — Хорооны нарийн бичгийн даргын орлогч. 1962 онд Хёого мужийн Кобэ хотод төрсөн. Нихондэнки пүүсийн дарга,

6. Накамура Канозэ - Хорооны нарийн бичгийн даргын орлогч. Нихонкоогёо пүүсийн дарга. 1922 онд Киото хотод төрсөн

7. Ямаширо Ёшинари — Хорооны нарийн бичгийн даргын орлогч. 1923 онд Канагава мужид төрсөн. Японы ган хоолойн пүүсийн дарга.

III. Японы ажил эрхлэгчдийн нэгдсэн холбоо

Хөдөлмөрийн ээдрээтэй асуудал, хамтын гэрээ хэлэлцээр, хөдөлмөрийн хуулийг тайлбарлах зэрэг өргөн хүрээтэй асуудлаар арга хэмжээ авах, ажилчдын эрхийг хамгаалахын тулд «хуулийг ил тод болгох»-ыг уриалж анх 1947 онд байгуулагдсан. Үйл ажиллагааныхаа хүрээнээс шалтгаалж «хөдөлмөрийн санхүүгийн бүлэг» гэж нэрлэгдэх болсон. Хөрөнгөтөн эзэн, ажилчдын хамтын ажиллагааг бэхжүүлж буй өнөө үед урьдын «японы ажил эрхлэгчдийн нэгдсэн холбоо»-ны тэмцлийн арга нь зөөлөрчээ. Засгийн газар болон парламентэд “хөдөлмөрийн бүх асуудлаар санал бодлоо зөвлөлддөг.

Сузуки Эйжи — Японы ажил эрхлэгчдийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч. 1913 онд Айчи мужийн Кира хотод төрсөн. Мицубиши-химийн аж үйлдвэрийн нэгдлийн захирал, 1937 онд Токиогийн худалдааны их сургууль (одоогийн Хитоцубашигийн их сургууль)-ийг төгсөөд Мицубишигийн харьяа химийн аж үйлдвэрийн пүүсэд орж ажилласан. Түүнээс хойш хэрэг эрхлэгч, санхүүгийн эрхлэгч, 1962 онд гэрээлэгч, 1964 онд үүрэг гүйцэтгэгч, 1970 онд мэргэжилтэн, 1973 онд пүүсийн орлогч дарга, 1974 онд пүүсийн дарга, 1984 оноос нэгдлийн дарга хийж байна. Энэ хооронд химийн ухааны нэгдсэн пүүсийн том эздийг сургасан. 1984 онд Японы ажил эрхлэгчдийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгчид дэвшин ажилласан. Санхүүгийн хүн болоод ч тэрүү амьдралын ухаанд суралцахад анхаарлаа хандуулсан. Амьдрал, ёс суртахууны талаар баримтлууштай асуудлыг тайлбарлан Эрүүлийг хамгаалах яам, эмч нарын холбоонд их нэр хүндтэй болсон. Мөн Кантоо хөдөлмөр эрхлэгчдийн холбооны дарга, аж амьдралын шинжлэх ухааны хорооны дарга гэх мэтийн ажлыг хавсран ажиллаж байна. 1987 онд 5-р сард хоёр дахь удаагаа холбооны даргаар томилогдсон.

2. Ооцуки Бумпэй – Холбооны хүндэт дарга. 1903 онд Миягэ мужийн Марумори хотод төрсөн. Мицубиши уул уурхай цементийн үйлдвэрийн зөвлөх.

3. Камэй Масао - Холбооны дэд ерөнхийлөгч. 1916 онд Хёого мужийн Кобэ хотод төрсөн. Сумитомо пүүсийн электротехникийн үйлдвэрийн нэгдлийн дарга.

4. Ханай Масао — Холбооны дэд ерөнхийлөгч. Айчи мужийн Отова хотод төрсөн. Тоёота машины үйлдвэрийн зөвлөх.

5. Ишибаши Каничиро — Холбооны дэд ерөнхийлөгч. 1920 онд Фукуока мужид төрсөн. Фурижистоны хүндэт ерөнхийлөгч,


6. Ийда Ёотаро-Холбооны дэд ерөнхийлөгч. 1920 онд Миягэ мужид төрсөн. Мицубишийн хүнд үйлдвэрийн нэгдлийн дарга,

7. Мики Акира — Холбооны дэд ерөнхийлөгч. 1921 онд Фукушима мужид төрсөн. Шиннихонсэйтэцү холбооны дарга.

IV. Японы худалдаа аж үйлдвэрийн танхим

ЯПОНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Бүх байгууллагын тоо - 100



«Худалдаа аж үйлдвэрийн танхимын хууль»-ийн дагуу 1953 онд байгуулагдсан. Токио, Осака зэрэг японы гол хотуудад байгаа худалдаа аж үйлдвэрийн нийт 494 гишүүн танхимыг эгнээндээ нэгтгэсэн төв байгууллага юм. Энэ танхимын онцлог нь жижиг, дунд үйлдвэрийн эрх ашгийг хамгаалдаг. Засгийн газар, парламентэд жижиг, дунд үйлдвэрт хамаарагдах арга хэмжээг дэвшүүлэхээс гадна, худалдаа аж үйлдвэр эрхлэгчдийг нэгтгэхийн тулд үйлдвэр, байгууллагуудын худалдааны харилцаа холбоонд таатай нөхцөл бүрдүүлэх, үзэсгэлэн худалдаа нээж ажиллуулах зэрэг ажлыг явуулах үүрэгтэй.

Ишикава Рокуроо — Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга. 1925 онд Токио хотод төрсөн. Кажима барилгын холбооны дарга. Эдийн засгийн байгууллагын холбоог үндэслэн байгуулагч тус холбооны дарга Ишигава Ичирогийн авьяаслаг 6 хүүгийн нэг юм. 1948 онд Токиогийн техникийн ухааны салбарыг төгссөнийхөө дараа аспирантурт дэвшин суралцаад аж үйлдвэрийн инженер мэргэжилтэй болсон. Тээврийн яам, улсын төмөр замд ажиллаж байгаад 1955 онд гэрээлэгч түшмэд, 1978 онд пүүсийн захирал, 1984 оноос барилгын хорооны ерөнхийлөгч болсон. Инженерүүдийн нийгэмлэгийн дарга, японы барилгын аж үйлдвэрийн байгууллагын нэгдлийн захирлыг хашиж байна. 1978 онд бүх

*«Японы Хөдөлмөр эрхлэгчдийн зохион байгуулалт» гэснийг «Японы хөдөлмөр эрхлэгчдийн нэгдсэн холбооны зохион байгуулалт» хэмээн залруулан уншина уу.

пүүсийн чанар шалгаж хянахыг пүүсүүдэд нэвтрүүлж амжилт гаргасан учир 1985 онд Дэмингийн шагналаар шагнагдсан, «системчилж сурах аргаар» үйлдвэрийн ажлыг удирдах нь» номын зохиогч юм. 1987 оны 12-р сард хоёр дахь удаагаа худалдаа аж үйлдвэрийн танхимын даргаар сонгогдсон.

2. Сажи Кэйзоо - Худалдаа аж үйлдвэрийн танхимын орлогч дарга. 1919 онд Осака хотод төрсөн. Осакагийн худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга, Мөн Сантори пүүсийн дарга,


3 Такэда Коотаро - Худалдаа аж үйлдвэрийн орлогч дарга, 1916 онд Айчи мужид төрсөн. Нагоя хотын худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга.

4. Уэно Ютака --Орлогч дарга, 1915 онд Канагава мужийн Ёкохама хотод төрсөн., Ёкохамагийн худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн дарга.

5. Цукамото Коичи - Орлогч дарга. 1920 онд Миягэ мужийн Сэндай хотод төрсөн. Киотогийн худалдаа аж үйлдвэрийн дарга,

6. Ишино Шиньичи — Орлогч дарга. 1912 онд Хёого мужийн Кобэ

ЯПОНЫ ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



«Эвлэлийн төлөөлөгчдийн газрын дарга» гэснийг «Брокерүүдийн төлөөлөгчдийн газрын дарга» хэмээн залруулан уншина уу

Япон хэлнээс орчуулсан Д. Цэцэгдарь